

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2020 ОНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| №                                                                                                                                                                                                                                                                                                | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа                                                                                                                                                           | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                                                        | Хугацаа | Хариуцах газар нэгж, албан тушаалтан | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b> |                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                               |         |                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 1                                                                                                                                                                                                                                                                                                | 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1. АТГ-т төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянуулахаар илгээх албан бичигтээ Төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлт, төрийн албаны шалгалт өгсөн баримт бичгийн хуулбарыг хавсаргах | 2020    | ТЗУХ, ЭБАТ                           | <p>2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/34 дугаартай албан бичгээр "Албан тушаалын тодорхойлолт"-ыг Агентлагийн даргын баталснаар урьдчилан илгээж тодорхойлолт авах хүсэлтийг илгээн хариу зөвлөмж чиглүүлгийг байгууллага хариуцсан комиссараас утсаар авч шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/36-01-40 дугаартай албан бичгээр хэлтсийн даргын албан тушаалд мерит зарчмаар шатлан дэвшин ажиллах болсон 5 албан хаагчийн ХАСУМ-ийн холбогдох материалуудыг бүрдүүлж хүргүүлсэн.</li> <li>- 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/59 дугаартай албан бичгээр ТЗ-6, ТЗ-7 ангилалын албан тушаалд нэр дэвшсэн болон өмнө нь эрхэлж байсан албан тушаалын чиг үүрэгт өөрчлөлт орсон 10 албан хаагчдын ХАСУМ-ийн холбогдох материалуудыг бүрдүүлж илгээсэн.</li> </ul> |
| 2                                                                                                                                                                                                                                                                                                | 4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан                                                                                                                                                              | 2. Төрийн албан хаагчийн ажлын байрны                                                                                                                                                                                         | 2020    | Бүх хэлтэс                           | 1. 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 05/12774 дугаартай Хувийн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |

|   |                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                |      |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | тодорхойлолтод тавигдсан нийтлэг шаардлагыг хангасан, ёс зүйтэй төрийн албан хаагчийг мерит зарчмыг баримтлан албан тушаалд томилох, дэвшүүлэх |      |            | <p>ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай албан бичгийг үндэслэн Агентлагийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Б/22-Б/26 дугаартай тушаалаар 5 хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нарыг томилсон.</p> <p>2. 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05/13465 дугаартай Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай албан бичгийг үндэслэн Агентлагийн даргын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Б/34-Б/35 дугаартай тушаалаар ТЗ-6, ТЗ-7 ангиллын 10 албан хаагчдыг холбогдох албан тушаалд томилов.</p> |
| 3 | 4.1.1.6. нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх                         | 3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх       | 2020 | ТЗУХ, ЭБАТ | <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Үндэсний геологийн алба” байгуулагдсан ба Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/254 тоот тушаалаар “Бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” батлагдсан. Энэ хугацаанаас эхлэн албан хаагчдыг ажлын байранд томилох болон холбогдох тушаал шийдвэрийг гарган 34 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн.</p>                 |

|   |                                                                                                           |                                                                                                                                                        |      |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                                                                                           |                                                                                                                                                        |      |            | <p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, агентлагийн даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар байгууллагын дотоодын журмыг батлан тус журмын 11 дүгээр хэсэгт Төрийн захиргааны албан хаагчийн ёс дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг дээдлэн мөрдөж, хэрэгжүүлэх тухай асуудлыг тусгасан.</p> <p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 6.2 –т заасан ёс зүйн зөвлөлийн гишүүдийн тоог тухайн байгууллагын төрийн албан хаагчдын тоог харгалзан 3-7 гишүүнтэй байхаар тогтооно гэсний дагуу агентлагийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны А/43 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.</p> <p>Тайлант хугацаанд ямар нэгэн ёс зүйн зөрчилгүй үүсээгүй бөгөөд ёс зүйн зөвлөл хуралдаагүй болно.</p> |
| 4 | 4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 4. АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулагдах болон цахим сургалтад шинээр томилогдсон албан хаагчдыг бүрэн хамруулах, тусгай шаардлагатай сургалтад | 2020 | ТЗУХ, ЭБАТ | 1. 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр АТГ-ын сургалтад Тэргүүн түшмэл-1, Эрхэлсэн түшмэл-1, Ахлах түшмэл-5, Дэс түшмэл-8 нийт 15 төрийн захиргааны албан хаагчийг хамруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |

|                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                        |                                                                                                                                                         |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                        | холбогдох албан хаагчийг сургах                                                                                                                         |      |      | <p>2. 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ЭБАТ-д зориулсан цахим сургалтад хамрагдсан.</p> <p>3. Байгууллагын дотоод сүлжээ /Эйбл/-нд АТГ-ын УССГХэлтсийн “Шүгэл үлээгчийг хамгаалах, хамтран ажиллах боломж, арга зам” сэдэвт сургалтыг цахим хэлбэрээр байршуулан нийт албан хаагчдын 75 хувь буюу 27 хүн судалж, танилцсан. /зураг хавсаргав./</p> |
| <b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>                    |                                                                                                                                        |                                                                                                                                                         |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 5                                                                                                                                                                                                                                               | 4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 5. төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх                            | 2020 | ГМТ  | Эрдэс баялгийн мэдээллийн хайлтын систем болох <a href="https://www.mris.mn/">https://www.mris.mn/</a> төрөлжсөн өгөгдлийн сангийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд интернетийн орчинд нээлттэйгээр хүргэж эхэлсэн.                                                                                                                                   |
| <b>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b> |                                                                                                                                        |                                                                                                                                                         |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 6                                                                                                                                                                                                                                               | 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох                                               | 6. Агентлагийн санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх | 2020 | ТЗУХ | 2020 оны 9 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба агентлагийн санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд орлого, зарлагын гүйлгээг бодит гүйцэтгэлээр хуулийн хугацаанд байршуулсан. Тайлант хугацаанд цалин /хөлсний зардлаас бусад/ 5,0 сая төгрөгийн дүнтэй гүйлгээ гараагүй болно.                         |
| <b>Арав. Шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b>                                                       |                                                                                                                                        |                                                                                                                                                         |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

|   |                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                 |      |            |                                                                                                                                                                                                                                                            |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7 | 4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 7. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 2020 | Бүх хэлтэс | <a href="https://ngs.gov.mn/">https://ngs.gov.mn/</a> хаяг бүхий агентлагийн вебсайтыг шинээр байгуулсан ба сайтад "Авлигын эсрэг үйл ажиллагаа" цонхыг нээж, авлигийн эсрэг ухуулан таниулах сурталчилгааны видео шторкыг байршуулсан. /зураг хавсаргав./ |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

ТАНИЛЦСАН:

ДАРГА

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН: ТЗУХ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН



О.ЧУЛУУН

С.ШИНЭ-ОД

Х.МӨНГӨНЖИГҮҮР